

2015 он 11 сар 03 өдөр

Дугаар 2015/26

Улаанбаатар хот

## ТУЗ-ИЙН ТОГТООЛ

Эцнээ санал хураалт явуулах

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1 болон 73.3 дэх заалтууд, төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн төлөөлөн удирдах зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. 2014 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг хаалттай ХК болж хэлбэрээ өөрчлөхийг зөвшөөрсөн бөгөөд зарим хувьцаа эзэмшигчид өөрчлөгдсөнтэй холбоотойгоор тус хурлаар баталсан Хаалттай ХК-ийн дүрмийг дахин баталгаажуулах шаардлага үүссэн тул 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрөөр дуусгавар болгон эцнээ санал хураалтыг явуулсугай.
2. Эцнээ санал хураалт явуулах замаар Хаалттай ХК-ийн дүрмийг баталсугай.
3. Эцнээ санал хураалтад оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2015 оны 11 дүгээр сарын 3-ны өдрөөр тогтсугай.
4. Доорх бичиг баримтыг 2015 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс эхлэн 09.00-18.00 цагийн хооронд Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн байранд болон компанийн албан ёсны сайт дээр байршуулж хувьцаа эзэмшигчид танилцах боломжийг хангаж ажилласугай. Үүнд:
  - 4.1. Эцнээ санал хураалт явуулах тухай төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэр;
  - 4.2. 2014 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол;
  - 4.3. Эцнээ санал хураалтаар батлах дүрэм болон түүний тогтоолын төсөл.
5. Эцнээ санал хураалт явуулах шийдвэр гарсантай холбогдуулан санал өгөх эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд эцнээ санал хураах зарыг 2015 оны 11 дүгээр сарын 4-ний өдрөөс бүртгэлтэй мэйл хаяг болон компанийн албан ёсны вэб сайтаар дамжуулан хүргэхийг тооллогын комисст даалгасугай.
6. Эцнээ санал хураалтаар ирүүлсэн саналыг тоолох, дүнг гаргах ажлыг зохион байгуулах тооллогын комиссоор Ц.Должин, Д.Энхбилэг, Э.Цолмон нарыг томилж, комиссын даргаар Д.Энхбилэгийг томилсугай.
7. Эцнээ санал хураалтын саналын хуудсыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
8. Саналын хуудсыг 2015 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр хувьцаа эзэмшигчдэд мэйлээр хүргүүлэх, хувьцаа эзэмшигчид өөрийн биеэр ирж, оффис дээрээс авах боломжоор хангасугай.
9. Саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2015 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн 18.00 цагт Ард Санхүүгийн Нэгдэлийн хаяг болох УБ хот, СБД, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Номын Хишиг ХХК-ийн байр, 2 давхарт хүлээн авахаар шийдвэрлэсүгэй.

ТУЗ - ИЙН ДАРГА

ЖАНЧИВЫН ОЮУНГЭРЭЛ



## АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ ХХК-ИЙН ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН САНАЛЫН ХУУДАС

Хувьцаа эзэмшигчдийн эчнээ санал хураалтын саналыг 2015 оны 11 дүгээр сарын 9-ний  
өдрийн 18.00 цагт хүртэл Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн өөрийн байр болох УБ хот, СБД,  
8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Номын Хишиг ХХК-ийн байрны 2 давхарт хүлээн  
авна.

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр/аж ахуй нэгжийн нэр: .....  
Төлөөлж байгаа байгаа этгээдийн овог, нэр .....  
Регистрийн дугаар..... Хаяг .....  
Эзэмшиж буй хувьцааны тоо.....

| Эчнээ саналаар гаргах шийдвэр     | Зөвшөөрсөн | Татгалзсан | Түдгэлзсэн |
|-----------------------------------|------------|------------|------------|
| 1. Хаалттай ХК-ийн дүрмийг батлах |            |            |            |

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг..... /

Тамга /аж ахуй нэгж бол/

Санамж:

- Саналын хуудсыг хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн байранд өөрийн биеэр ирж, бичиг баримтаа шалгуулан өгч болно.
- Саналын хуудсыг шуудангаар хүргүүлэх тохиолдолд өөрийн иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргана.
- Итгэмжлэлээр оролцож байгаа бол итгэмжлэхийн саналын хуудсын хамт хавсаргана.
- Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудасыг хүчингүйд тооцно.

Саналын хуудсыг хүлээн авсан ажилтан ..... /

### Тооллогын комисс-ийн хэрэгцээнд:

Санал авахыг хуудсыг хүчингүйд тооцсон бол шалтгаан.....

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон ..... /  
Тооллогын комиссын дарга ..... /  
Гишүүн..... /  
Гишүүн..... /